

УЛС ТӨРИЙН ФИЛОСОФИЙН СТАТУС: ШИНЖЛЭХ УХААН ЭСВЭЛ ХҮМҮҮНЛЭГИЙН МЭДЛЭГ ҮҮ?

Д.Болд-Эрдэнэ (Доктор Sc.D, профессор)
Философийн хүрээлэн, ШУА

Түлхүүр үг: Философи, философи сэтгэлгээ, улс төрийн философи, шинжлэх ухаан, хүмүүнлэг мэдлэг,

Философийн онцлогтой холбогдуулан зарим тохиолдолд “статус” хэмээх харьцангуй эмпирик шинжтэй нэр томъёог хэрэглэж болох юм шиг санагддаг. Эрх зүйн философид “статус”(status)хэмээх нэр томъёог аливаа субъектэд олгогдсон эрх зүйн хэм хэмжээ, эрх зүйн байдал гэсэн агуулгаар гол төлөв ойлгогддог бол улс төрийн философид уг нэр томъёог хэрэглэсэн тохиолдолд түүнийг философи мэдлэгийн бүхэл тогтолцоон дахь бие даасан өөрөөрөө байгаа байдал, нөлөө, онцлогийн хүрээ зааг гэсэн агуулгаар томъёолон баримжаалж болохоор байдаг. Иймд улс төрийн философийн статусын асуудал нь уг чанартаа түүний бусдаас ялгарах онцлогийн тухай асуудал юм.

Философи (улс төрийн философи), шинжлэх ухааны ялгаа, онцлог

Улс төрийн философийн онцлогийн асуудлыг тойрсон маргааны явцад түүнийг шинжлэх ухаан мөн эсэхтэй холбогдсон асуудал онцгой тавигддаг. Энэ нь саяханаас яригдаж буй асуудал биш, харин философи сэтгэлгээний түүхэн дэх маргааны том сэдэв болсоор иржээ. Энэ асуудал дээр томоохон философичдын санаа бодол ч харилцан адилгүй байсан. Лейбниц, Декарт, Кант, Гегель, Маркс, Энгельс, Гуссерль гэх зэрэг цөөнгүй философичид философийг шинжлэх ухаан гэж үзэх талд байсан бол нилээдгүй философичид философийг шинжлэх ухаанаас ялгаж үздэг. Гэхдээ философийг шинжлэх ухаан гэж үздэг хандлага өнөө ч хүчтэй хэвээр байна. Философич В.А.Канке тэмдэглэхдээ “Философид эмх цэгц, нотолгоо, шалгуур байдаг болов уу? Тиймээ байгаа. Хэргийн учир юунд байна вэ? гэхлээр дээрх шинжүүдийг зөвхөн философи л боловсруулан гаргасан. Тэгэхлээр философи өөрийн амжилтуудыг удирдлага болгодог нь тодорхой. Философич байнга итгэлтэй байхыг хичээж, өөрсдийн дүгнэлтийг үндэслэлтэй гаргаж, тэдгээрийг бодит баримтуудаар шалган баталгаажуулдаг. Энэ үүднээс философийг шинжлэх ухаан гэж хүлээн тооцож болох ба тооцох ч хэрэгтэй

юм”¹ гэж бичсэн.

Философи шинжлэх ухаан мөн эсэх асуудалд нэг мөр хариу өгөхөд хүндрэлтэй байдгийг юуны түрүүнд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Учир нь асуудлыг шийдлийн дээрх хоёр хувилбарын алинаар нь шийдлээ гэсэн ямар нэг эргэлзээ зайлшгүй бий болдог. Тухайлбал философийг мэдлэгийн тогтолцоо гэдэг талаас нь авч үзвэл шинжлэх ухаан гэж хэлж болохоор ч юм шиг, харин философи нь шинжлэх ухаанаас бүр өмнө оршин үйлчилж, оршихуйн үзэгдлүүдтэй тулж биш хийсвэр байдлаар дам харьцдаг юмсын мөн чанарын чинадад нэвтрэх, хүний сэтгэхүйн оюунлаг арга, аливааг эргэцүүлэн сэтгэх онцгой чадвар гэдэг талаас нь хандвал шинжлэх ухаанаас арай өөр мэдлэгийн тогтоц ч байж болохоор санагддаг. Тэр ч байтугай энэ бүхэнтэй холбоотой мэдлэг гэж ер нь юу вэ, шинжлэх ухаан гэж юу вэ?, мэдлэг, шинжлэх ухаан хоёр нь нэг зоосны салшгүй хоёр тал лугаа адил зүйл үү, эсвэл тэдгээрт бага зэрэг ч атугай ялгаа онцлог бий юу?, философи ер нь мэдлэг мөн үү? гэх зэрэг шийдэж хариу өгвөл зохих дагалдах олон асуудал гарч ирдэг. Харамсалтай нь энэ бүхэнд одоогоор нэг мөр хариу өгөхөд мөн л төвөгтэй

¹ В.А.Канке. Философийн үндсүүд. УБ., 2011, 10-11 дэх тал

байгаа юм. Хэдий тийм боловч философийг шинжлэх ухаанаас ялгаж үздэг хандлага нилээдгүй жин дарах болсоныг анхаарах хэрэгтэй байх шиг байна. Тэгэхлээр үүнд анхаарлаа хандуулж, холбогдох зарим нотолгоо, үндэслэлүүдийг анзаараад үзэхээр хүлээж авч болохоор зүйл ч тааралдаж буйг тэмдэглэмээр байна.

Философи тэр дундаа улс төрийн философийг цэвэр шинжлэх ухаан хараахан биш харин шинжлэх ухаанч чанарыг өөртөө агуулсан хүмүүнлэгийн мэдлэгийн салбар гэх байр суурь нилээдгүй байдаг. Тэгэхлээр зохиогчийн хувьд энэ үзэл байр суурьт тал өгөхийн зэрэгцээ үүнтэй холбогдуулан зарим зүйлийг тодотгон тайлбарлах нь зүйтэй байх гэж үзлээ. Ингэхдээ нэр хүнд бүхий зарим томоохон философичид болох В.Виндельбанд, Г.Стурве, П.С. Юшкевич, И.Я.Грот, Б.Рассел нарын үзэл бодлыг иш үндэс болгож буйг онцлоё.

Германы философич В.Виндельбанд “Хэрэв философи гэж нэрлэгдэж байгаа бүхэн шинжлэх ухаан байх эрмэлзлэлтэй бөгөөд зорилтоо зөв шийдвэрлэсэн үед шинжлэх ухаан болж чадах юм гэдгийг тогтоож болдогсон бол философи өөрөө төгс бус ч гэсэн шинжлэх ухаан гэж нэрлэгдэж болохсон билээ. Гэвч энэ нь хэрэг дээрээ биелсэнгүй”² гээд цааш нь “...түүхчийн атгаг бус хараа л философийг ямар нэг загварт хашиж боломгүй соёлын ээдрээтэй, хувирамтгай үзэгдэл юм гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Ихэд дэлгэрсэн философийг шинжлэх ухаанд захируулах явдал бол философийн хувьд ч, шинжлэх ухааны хувьд ч шударга бус зүйл юм гэдгийг тэр ойлгоно. Философийн хувьд өргөжих эрмэлзлэлд нь дэндүү явцуу хязгаар тавьж байгаа учраас, шинжлэх ухааны тухайд бусад олон эх сурвалжаас философи өөртөө авч байгаа бүхний төлөө хүлээх хариуцлагыг түүнд үүрүүлж байгаа учраас шударга бус юм”³ гэж тухайн үедээ бичиж байжээ. Тэгэхлээр философи болон тодорхой шинжлэх ухааны хоорондын ялгаа онцлог, тэдгээрийн харилцан хамаарлын тухай асуудал цоо шинэ зүйл биш байх нь.

Кантынхаар “...философи бол хүний оюун ухааны эцсийн зорилгод аливаа

мэдлэг болон оюун ухааныг хэрэглэх харилцааны тухай шинжлэх ухаан юм. Тэр зорилгод бусад бүх зорилтууд захирагдаж, түүн дотор нэгдлээ буй болгох учиртай. [...] Философи шинжлэх ухааны хүрээг хаах мэт барьж, түүний дүнд шинжлэх ухаанууд анх эмх цэгц, харилцаа холбоогоо олж авдаг учраас философи бол энэ дотоод сэтгэл ханамжийг бидэнд өгөх чадвартай ганц шинжлэх ухаан юм”⁴ мөн аж. Тэгэхдээ ингэлээ гээд тэрээр философийг шинжлэх ухаан гэхээсээ мэдлэг оюуныг хэрэглэх арга гэдэг талаас нь илүүтэй онцолж байсан нь ойлгогддог.

Улс төрийн философи, шинжлэх ухааны мэдлэгийн тодорхой ялгаа зааг юугаар нөхцөлдөж байна вэ? гэсэн асуулт анхаарал татсан сонирхолтой сэдвийн нэг юм. Философич В.Виндельбанд “...философийг түүхэн үзэгдлийн хувьд шинжлэх ухааны ойлголтод тооцож болох юм гэж бодъё. Тэгэхэд энэ төрлийн хүрээн дотор онцгой дүрс болсон философи бусад шинжлэх ухаанаас юугаараа ялгаатай юм бэ гэдэг багагүй хүнд асуудал үүснэ. Энэ ...асуултад түүх нийтлэг гарцаагүй хариу өгөөгүй байна”⁵ гэж бичсэнийг үүнтэй холбогдуулан онцлохыг хүсч байна. Хэдий тийм боловч философи, шинжлэх ухааны ялгаа онцлогийн тухайд зарим зүйлийг тодруулж болох юм шиг санагддаг.

Философи (улс төрийн философи ялгаагүй Д.Б), шинжлэх ухаан ялгаатай. Философич Бэртран Рассел энэ тухай бичихдээ “Шинжлэх ухаан өгөгдөж буй баримттай харьцдаг бол философи бодол эргэцүүлэлтэй харьцдаг”⁶ гэсэн байдаг. Эндээс улс төрийн философийг улс төрийн үзэгдлийн метафизик мөн чанарыг авч үздэг мэдлэгийн хэлбэр гэж үзэж болно. Тэгвэл шинжлэх ухаан нь өөрийн судлагдахууныг “барьж үзэх”-ийг эрмэлздэг, харьцангуй эмпирик, мета бус шинжтэй байдаг.

Улс төрийн философи, шинжлэх ухааны хоорондын ялгаа нь тэдгээрийн судлагдахууны болон аргын ялгаагаар илэрч байдаг. Улс төрийн философи нь улс төрийн эмпирик баримтыг ашигладаг боловч түүн дээр шууд суурилдаггүй, шинжлэх ухааны тусгай аргуудыг орлодгүй. Энэ

² “Хрестоматия по философии”. М., 1998. С.46

³ Мөн тэнд. 47 дахь тал

⁴ И.Кант “Логика”-Трактаты и письма. М., 1980, С.331, 334

⁵ “Хрестоматия по философии”. М., 1998. С.47

⁶ Бэртран Рассел. Өрнийн мэргэн ухаан. УБ., 2011, 13 дахь тал.

агуулгаараа физик, хими, биологи болон бусад тусгаар шинжлэх ухаан шиг шинжлэх ухаан биш юм. Бодит байдлын тусгай тусгай талууд тодорхой, тусгаар шинжлэх ухааны судлагдахуун болдог бол улс төрийн ертөнцийн бүхэллэг чанар, түүнтэй холбогдох хүний холбогдлын асуудал нь улс төрийн философийн судлагдахууны суурь үндэс нь болдог. Улс төрийн философи нь танин мэдэхүйн эмпирик аргуудыг шууд ашиглахгүй боловч онолын сэтгэхүйн хүчээр өөрийн асуудлыг шийдвэрлэж, улс төрийн бүх шинжлэх ухаанд түгээмэл ач холбогдолтой танин мэдэхүйн нэн түгээмэл аргуудыг, ойлголтын тогтолцоог боловсруулдаг.

Улс төрийн философи, шинжлэх ухааны ялгаа нь мэдлэгийн шалгагдах онцлогоор бас тодорхойлогддог. Шинжлэх ухааны онолыг туршилт сорилт болон эмпирик судалгаагаар батлах буюу няцааж болдог. Тэгвэл улс төрийн философид ингэх боломж хязгаарлагдмал байдаг. Б.Рассел “Баримтыг шинжлэх ухааны аргаар яг байгаагаар нь үзүүлэх явдал философийн судалгааны жинхэнэ зорилт бишээ. Энэхүү заагийг нягтлан үзээгүйгээс систематик идеалистууд тухайн үедээ будлин төөрсөн юм. Эмпирик судалгааны үр дүнг авч үзэх, шинжлэх ухааны ололтуудыг тодорхой эрэмбэнд оруулах ерөнхий тогтолцоог тогтоох арга замуудыг философи өгдөг”⁷ хэмээн бичсэн байдаг.

Улс төрийн философи, шинжлэх ухааны мэдлэгийн ялгагдах онцлог нь тэдгээрийн хүрээн дэх онолын мэдлэгийн уламжлагдах болон оршин үйлчлэх шинж байдлаар нөхцөлддөг. Шинжлэх ухаанд онолын нэг тогтсон парадигм ноёрхох эсвэл нэг онол нөгөөгөөс уламжлагдан гарах, шинэ онол, хуучин онолдоо суурилан уламжлагдах нь элбэг байдаг бол улс төрийн философид эсрэг тэсрэг философийн баримтлалууд “эв нэгтэй” зэрэгцэн оршиж болдог. Нэг үгээр хэлбэл улс төрийн философи нь шинжлэх ухаантай харьцуулахад онол, үзлийн плюраль шинжтэй байдагаараа онцлог юм.

Тодорхой шинжлэх ухаан болон улс төрийн философи хоёрын хоорондох ялгааны нэг үндэс нь тэдгээрт агуулагдаж байдаг тусгай ба нийтлэг зүйлийн ялгаа

юм. Философич Г.Стурве “Философи бол уг чанартаа бүхнийг хамарсан, түгээмэл ерөнхий...юм. Үүгээрээ нарийн тодорхойлогдсон тодорхой зүйлийн судалгаагаар хязгаарлагдсан, ямагт тусгай шинжтэй байдаг бусад бүх шинжлэх ухаанаас ялгагддаг юм. Ийм учраас тусгай шинжлэх ухаануудаас өвөрмөц судалгааныхаа үндсэн дээр ертөнцийг үзэх нийтлэг үзлийг бий болгож, түгээмэл шинжтэй болохыг шаардаж болдоггүйтэй нэг адил нийтлэг ертөнцийг үзэх үзлийг боловсруулах үндсэн зорилттой нь шууд холбоогүй тусгай асуултуудыг тавихыг философиос шаардах аргагүй юм”⁸ гэсэн байдаг. Ингэхлээр эндээс үзвэл нийтлэг шинж бүхий философи, тусгай мэдлэг бүхий шинжлэх ухааны хооронд тодорхой ялгаа байдаг нь харагдаж байна.

Шинжлэх ухааны мэдлэг нь их төлөв оршихуйн үзэгдлийн тусгай тодорхой мэдлэг байдаг бол улс төрийн философийн мэдлэг нь улс төрийн үзэгдлийн тухай философид хамаарсан түгээмэл, нийтлэг шинжтэй мэдлэг байдаг. Философич П.С.Юшкевич бичихдээ “философи болон шинжлэх ухааны хоорондын ялгааг тэдгээрийн судалгааны зүйл ялгаатай байдагаар, бас философи нь ерөнхийд, шинжлэх ухаан нь тусгайд чиглэсэн байдагаар, эсвэл нэгдэх нь юмсын үнэмлэхүй мөн чанарыг, хоёрдахь нь харьцангуй үзэгдлийг судалдагаар ихэвчлэн тайлбарладаг”⁹ гэжээ. Ингэхлээр философи нь тусгаар шинжлэх ухаантай харьцуулахад ертөнцийг нэгдэлд нь бүхэллэг байдлаар авч үзэхдээ нэн ерөнхий шинж холбоог ялган тэндээс жижиг, тусгай зүйлийг орхиж, ертөнцийг бүхэл нэгдмэл дүр төрх, агуулгаар нь танин барьж байдаг. Энэ агуулгаараа шинжлэх ухааны мэдлэг нь илүү тодорхой, тусгай байдагаараа философийн мэдлэгээс ялгаатай.¹⁰

Шинжлэх ухаан, философийн ялгагдах онцлогийн нэгэн үндэс нь тэдгээрийн мэдлэгийн ерөнхий шинж байдлаар нөхцөлддөг. Шинжлэх ухаан нь мэдлэгийн ерөнхий шинж байдлын хувьд үндсэндээ онол болдог бол философи нь өмнө тэмдэглэсэнчлэн арга зүй болж байдаг.

⁸ “Хрестоматия по философии”. М., 1998. С.42

⁹ Мөн тэнд. С.144

¹⁰ Г.Чулуунбаатар. Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик, судалгааны ажлын арга зүй. 54 дахь тал.

⁷ Бэртран Рассел. Өрнийн мэргэн ухаан. УБ., 2011, 511 дахь тал.

Онол, арга зүй буюу онол, философи нь хоорондоо нягт нарийн холбоотой боловч ялгагдах онцлог байдаг. Хэрвээ онол нь шинжлэх ухааны мэдлэгийн цогц илэрхийлэл байдаг бол арга зүй нь онолын мэдлэгийн суурь үндэслэл тэдгээрийг хэрэглэх арга, зарчим, хэм хэмжээний тухай ерөнхий үзэл баримтлал болж байдаг.

Эцэст нь улс төрийн философи, шинжлэх ухаан хоёрыг ялгах бас нэг нь онцлог нь тэдгээрийн зорилго, үр дүнгээс ихээхэн хамаарч байдаг. Хэрвээ шинжлэх ухаан нь тодорхой асуудлыг гаргаж тавьсан бол түүнийг аль болохоор эцсийн байдлаар нь шийдэх, шалгах, нягтлах тэр үндсэн дээр шийдлийн тодорхой нэг хувилбарыг санал болгохыг эрмэлзэж байдаг бол улс төрийн философи нь ингэх зорилго тавьдаггүй харин асуудлын байж болох шинж, учир зүй, дотоод, гадаад шалтгаан, хүчин зүйл, холбоо хамааралын олон хувилбар санааг бясалган эрэгцүүлэх байдлаар зөвхөн гарган тавьж байдаг.

Улс төрийн философийн “шинжлэх ухаанч” чанар

Философийг “*шинжлэх ухааны шинжлэх ухаан*” гэж үзэх хандлага эрт үеэс улбаатай. Гэхдээ философийг шинжлэх ухаанаас бүр өмнө оршин үйлчилж байсан гэж үздэг. Хэдийгээр шинжлэх ухааны түүх нэн эртнээс эх үүсвэртэй ч түүний үзэгдлийн хувьд цэгцэрч хэлбэршин хөгжих үйл явцыг хожуу XVI-XVII зууны үетэй холбон үздэг. Эндээс үзвэл философи, шинжлэх ухаан хоёрт ялгаа зааг байх нь тодорхой байна.

Хэдийгээр ингэж улс төрийн философи, шинжлэх ухаан хоёрыг ялгаж үзлээ гээд тэдгээрийн хоорондын амьд холбоог бүрхэгдүүлэн, тусгаарлах нь учир дутагдалтай. Хэрэв тэдний хооронд оршиж байдаг амьд холбоо хамаарлыг үгүйсгэх буюу бүдгэрүүлэх гэж оролдох нь угаасаа хандлага юм. Ер нь улс төрийн философи ба шинжлэх ухаан хоорондоо ялгаатай нь улс төрийн философид ерөөс шинжлэх ухааны шинж байхгүй гэсэн үг огт биш юм. “Философи бол шинжлэх ухаан биш, харин шинжлэх ухааны төрхтэй юм”¹¹ гэж философич П.Л. Юшкевич бичсэн нь зөв логик юм.

Улс төрийн философийн сургаал, номлол тусгаар шинжлэх ухааны нэгэн адил оюунлаг танин мэдэхүй дээр тулгуурладагаараа, үндэслэл, дүгнэлтээ цэгцтэй үндэслэгээтэй гаргадагаараа, объектив бодит мэдлэгт хүрэх гэсэн эрмэлзлэлээрээ тэдгээр нь нийтлэг олон шинж байдаг. Түүний энэхүү шинжүүд нь улс төрийн философийг шинжлэх ухаанд ойртуулж, домог зүй ба шашинаас, мөн иррационал философиос ялгаж байдаг.

Улс төрийн философи, шинжлэх ухаан хоёр ялгаатай боловч хоорондоо нягт холбоо хамааралтай. Улс төрийн философи нь улс төрийн тусгаар шинжлэх ухааны мэдлэгийг ерөнхий онол, зарчим, аргын үүднээс задлан шинжилж, нэгтгэн дүгнээд түүнийг хэрэглэдэгээрээ улс төрийн философи хийгээд улс төрийн тусгаар шинжлэх ухааны мэдлэгийн холбоо хамаарал илэрч байдаг. Улс төрийн философи, улс төрийн шинжлэх ухааны мэдлэгийн тодорхой салбарууд харилцан үйлчилж, бие биеэ нөхөн сэлбэж, нөхцөлдүүлж байдаг. Шинжлэх ухааны тодорхой баримт, асуудалтай холбоогүй улс төрийн философи мэдлэг нь улс төрийн хоосон номчирхосон, улс төрийн бодит байдлаас тасархай хийсвэр, оюунаар үзэхүйн схем зохиоход хүргэдэг. Тэрчлэн улс төрийн философийн ерөнхий арга зарчимд сууриллаагүй улс төрийн тусгаар тодорхой мэдлэг нь улс төрийн эмпирик баримтыг тоочих, бүртгэн тэмдэглэх, эмхлэн цэгцлэхээс хэтэрдэггүй.

Философи нь ерөнхий арга зүй болж байдаг агуулгаараа шинжлэх ухааны олон чиглэл салбаруудтай холбогдож байдаг. Б.Рассел “Тодорхой салбарын шинжлэх ухааны судалгааны эрэл хайгуул философийнхтой адилгүй байдаг билээ. Гэхдээ шинжлэх ухаан бол философи эрэгцүүлэлийн нэг эх сурвалж мөн. Бид ерөнхий утгаар нь шинжлэх ухаанч байна гэдэг нь юу гэсэн үг вэ гэдгийг авч үзэх үедээ философи асуудал руу орчихож байгаа хэрэг юм. Шинжлэх ухааны аргын тухай авч үзэх нь философийн судалгаа мөн”¹² гэж бичсэн нь санамсаргүй хэрэг биш юм. Улс төрийн философи нь улс төрийн мэдлэгийн олон салбарыг нэгтгэн холбож, тэдэнд хэрэгтэй улс төрийн оршихуйн түгээмэл нэгдмэл дүр төрх, нийтлэг үзэл баримтлалыг гаргаж

¹¹ “Хрестоматия по философии”. М., 1998. С.154

¹² Бэртран Рассел. Өрнийн мэргэн ухаан. 511 дахь тал.

өгдөг. Ер нь улс төрийн тусгаар тодорхой мэдлэгүүд нь улс төрийн философийг улс төрийн бодит байдалтай холбож, эмпирик бодит баримт материалаар хангаж өгдөг бол улс төрийн философи нь эргээд тэдэнд онол, зарчим, үндэслэгээ, шийдлийн ерөнхий арга зүйг өгч байдаг.

Улс төрийн мэдлэгийн олон салбарт ерөнхий онолын философи асуудлууд ямагт тулгарч байдаг бөгөөд тэдгээрийг гагцхүү улс төрийн философийн боловсруулан тавьсан гаргалгаа, дүгнэлт, шийдэл, философийн ерөнхий онолын зарчмын тусламжтайгаар л шийдвэрлэх боломжтой байдаг. Нэг үгээр хэлбэл улс төрийн философийн боловсруулсан танин мэдэхүйн арга зүй, ойлголтын ерөнхий аппаратыг улс төрийн тусгаар тодорхой мэдлэгийн салбарууд идэвхтэй ашиглаж байдаг.

Түүнээс гадна улс төрийн философийн шинжлэх ухаанч шинж бол түүний шинжлэх ухаантай холбогдох чухал шижим болдог. Улс төрийн философийн шинжлэх ухаанч шинж нь түүний гаргаж тавьж буй үндэслэгээ, гаргалгаа, мөрдлөг дүгнэлтүүд нь логикийн хувьд яв цав зөрчилгүй, хоёрдмол санаагүй, даацтай, бодит баримтанд суурилсан, аль ч талаасаа хангалттай үндэслэгдсэн оюунлаг байдлаар тодорхойлогддог. Түүний энэ шинжлэх ухаанч чанар нь улс төрийн тусгаар олон мэдлэгийг өөртөө холбон ойртуулах үндэс болдог. Үүний нэг адил шинжлэх ухааны аль нэг мэдлэг тухайлбал байгалийн шинжлэлийн тодорхой салбар хөгжлийнхөө нилээд гүнгийрсэн шатанд хүрч, онолжсон хэлбэртэй болоод ирэхлээрээ мета шинжтэй болох нь байдаг. Жишээ нь: Альберт Энштейны “харьцангуйн онол”, Макс Планкийн “квант механикийн онол”, Чарльз Дарвины “хувьсалын онол” болон орчин үеийн стандарт модель, их нэгдлийн онол хийгээд амьдрал, ертөнцийн үүслийн тухай биологи, одон орны бусад онолуудыг дурьдаж болно. Ингэж шинжлэх ухаан онолжиж, мета шинжтэй болж байна гэдэг нь шинжлэх ухааны мэдлэгийн тэрхүү хэлбэр харьцангуй философшиж байна гэсэн үг юм.. Энэ бүхнээс тоймлож үзвэл улс төрийн философи нь шалгадаг шинжлэх ухаанаас нилээд ялгаа онцлогтой болов ч улс төрийн мэдлэгийн бусад салбаруудтай холбоотой

төдийгүй өөрөө тодорхой шинжлэх ухаанч шинжийг агуулдаг нь харагдаж байна.

Улс төрийн философи хүмүүнлэг мэдлэг болох нь Улс төрийн философийн онцлог тэр дундаа философи, шинжлэх ухааны харьцааны асуудлыг тойрсон маргаан нь үзэл бодлын мэтгэлцээний эрүүл үзэгдэл мөн гэдгийг харуулах, нөгөө талаас улс төрийн философи мэдлэгийн онцлогийн талаарх харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн нэгдмэл байж болох гаргалгаа, шийдэлд хүрэх чухал нөхцөл болдог. Тэгэхлээр улс төрийн философи нь шинжлэх ухааны тусгай тодорхой хэлбэрүүдээс ялгагдаж байдаг юм бол түүний оюунлаг хэмээгдэх мэдлэгийн онцлог нь юу байж болох вэ? гэсэн асуудал эндээс зүй ёсоор тавигдаж байна.

Хүн төрөлхтөний мэдлэгийн тогтолцоог нэгд шинжлэх ухаан (science) буюу байгаль, техникийн мэдлэгийн салбарууд; хоёрт нийгмийн шинжлэх ухаан (social sciences) буюу социологи, улс төр, төр, эрх зүй, орон судлал, түүх гэх зэрэг; гуравт хүмүүнлэгийн ухаан (humanities) философи, шашин судлал, хэл шинжлэл, соёл судлал гэх зэргээр ялгаж үздэгтэй холбогдож байна. Энэ үүднээс үзвэл философи болон улс төрийн философийг шинжлэх ухаан гэдэг агуулгаар бус, харин мэдлэгийг хэрэглэх арга гэдэг талаас нь шинжлэх ухаанч шинжийг агуулсан хүмүүнлэгийн мэдлэгийн хэлбэр гэж үзэх нь зохилтой байна. Учир нь хүмүүнлэгийн мэдлэгийн салбарууд нь их төлөв нийгмийн оюун санааны “үйлдвэрлэл”-тэй холбоотой байж, оюунлаг хийсвэр чанараараа мэдлэгийн бусад салбараас ялгагддаг. Тийм болохоор философи нь шалгадаг ухааны салбараас ялгагдах онцлог бүхий хүмүүнлэг, оюунлаг арга зүйн мэдлэгийн хэлбэр хэмээж болох байна.

Философид оногдож буй хувь тавилан улс төрийн философид бүрэн хамаарна. Учир нь улс төрийн философи бол угтаа философи мөн. Философич Бэртран Рассел философийг теологи, шинжлэх ухаан хоёрын хооронд оршиж байдаг мэдлэгийн салбар хэмээсэн байдаг. Тэрээр энэ тухай бичихдээ: “Бидний ойлгож байгаагаар философи гэдэг нь теологи болон шинжлэх ухааны хооронд оршигч ямар нэг завсрын

зүйл мөн. Теологитой адилаар тэрээр тодорхой мэдлэгийг өнөөг хүртэл хэрэглэх аргагүй байгаа тийм зүйлсийн хувьд хэрэглэгдэх боловч, шинжлэх ухааны адилаар тэрээр уламжлал, ил тод нээлтийн нэр хүнд гэхээсээ илүүтэйгээр хүний оюун ухаанд татагдаж байдаг. Миний үзэж байгаагаар тодорхой бүх мэдлэгүүд шинжлэх ухаанд хамаардаг ба харин бүхий л догмууд тодорхой мэдлэгийн хүрээнээс халин гардаг учраас теологийн хүрээнд хамаарна. Гэтэл теологи болон шинжлэх ухааны хооронд “Хэний ч бус газар нутаг” оршиж, хоёр талаасаа довтолгоонд өртөж байдаг нь философи юм”¹³ гэсэн байдаг. Ингэхлээр Б.Расселийн онцолсон тэрхүү “хэний ч бус газар нутаг” нь мөн л улс төрийн философи болж таарч байна. Тэгэхлээр эндээс теологи, шинжлэх ухаан хоёрын завсар байдаг улс төрийн философи нь мэдлэгийн салбарын хувьд чухам ямар гээч ухаан юм вэ? гэсэн асуудал зүй ёсоор гарч ирнэ.

Философи, тэр дундаа улс төрийн философи нь хүн төрөлхтөний олон үеийн турш хуримтлуулсан мэдлэгийн ерөнхий хүрээ, тойрогт багтаж байдаг. Түүнээс нэг их хальж, онцгойроод байдаггүй. Энэ нь түүний шинжлэх ухаанч шинжээр илэрдэг. Гэхдээ философи нь байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны бодит мэдлэгүүдээс ялгагдах онцлогтой. Ингэхлээр философи, улс төрийн философи нь хүн төрөлхтөний мэдлэгийн ерөнхий хүрээнд багтдаг ч баримт, үзэгдэлд шууд суурилдаг шалгадаг шинжлэх ухааны мэдлэгийн салбаруудтай харьцуулахад тэдгээртэй адилгүй харин ч тэдгээрээс ихээхэн ялгаатай. Тийм болохоор улс төрийн философи нь мэдлэгийн бие даасан салбар гэдэг нь гарцаагүй, тэгэхдээ энэ нь давтан хэлэхэд тодорхой шинжлэх ухааны салбараас ялгаатай хүний танин мэдэхүй, оюун санаатай илүүтэй холбогдож байдаг, хүний мэдлэг төдийгүй түүнээс халин гарсан гүнзгий хийсвэрлэл, сэтгэх арга барил, урлаг, ур чадвар болж байдаг чанараараа оюунлаг хийсвэр мэдлэг мөн. Нэг үгээр хэлбэл энэ нь хүмүүнлэг мэдлэг юм.

Өнөө үед хүмүүнлэг мэдлэгийн салбарыг оршин буй бодит юмс үзэгдлийн

баримтын тогтсон үнэлэмж, шууд ашгаа өгөгч эдийн засгийн үр ашигт мэдлэг талаас нь бус, харин хүмүүсийг соён гэгээрүүлдэг, тэдний оюуны чадвар боломжийг дээшлүүлэхэд тусалдаг, цэвэр ухааран гэгээрүүлэх, оюунжуулан чадваржуулах хийсвэр оюунлаг мэдлэг талаас нь харж, үнэлж байх нь зүйтэй санагдана. Орчин үед хүмүүнлэг мэдлэг нь хүнтэй шууд холбоотой түүний оюун ухаан, сэтгэлгээ, үнэлэмжтэй илүүтэй холбогддог, оюуны үйлдвэрлэлийн салбар, товчдоо хүнээс өөрөөс нь үүдсэн хүн судлалын өвөрмөц чиглэл, хүнийг оюуны талаас нь сорьж шалгаж байдаг түүний оюунлаг талын хэмжүүр, илэрхийлэл нь болдог. Иймдээ ч хүмүүнлэг мэдлэг нь уг чанартаа хүнтэй амин холбоотой, хүний мэдлэг, оюуны цогц илэрхийлэл байдаг.

Германы сонгодог философич Кант философид метафизик, ёс суртахуун, шашин, антропологи гэсэн дөрвөн бүрдэл байдаг гэж үзсэн боловч тэрээр философид хамаарах эхний гурван бүрдэл нь “...уг чанартаа антропологид хамаарах учраас энэ бүхнийг түүнд багтааж болно”¹⁴ гэж бичсэн нь санамсаргүй хэрэг биш юм. Энэ нь түүний төсөөлж байсанаар философи бол юуны түрүүнд ямагт хүнтэй холбоотой байж, түүний оюун ухаан, хийсвэрлэл, сэтгэх урлаг, ур чадварын дотоод нарийн илэрхийлэл болж, хүнийг аливаад үндэстэй эргэлзэх, буйртай эрэгцүүлэн бодож сэтгэхэд өдөөж байдагаараа нэг ёсны хүмүүнлэг мэдлэг юм. Харин энэ тохиолдолд хүмүүнлэг философи мэдлэгийг шалгадаг ухаантай шууд адилтгаж үл болно. Ингэхлээр философи түүний бүрдэл болсон улс төрийн философи нь мэдлэгийн онцлогийн хувьд философид хамаарах хүний оюун санаа, сэтгэх чадвартай холбоотой улс төрийн хүмүүнлэг мэдлэг мөн.

Нийгмийн болон хүмүүнлэгийн мэдлэгийн нийтлэг хийгээд ялгаа, онцлогийн тухай сэдэв нь анхаарч үзвэл зохих асуудал юм. Судлаачидын зарим хэсгийн хувьд нийгмийн хийгээд хүмүүнлэгийн мэдлэгийн нийтлэг талыг илүүтэй онцлоод тэдгээрийн ялгаа заагийг тэр болгон анхаарч харгалздаггүй тал байдаг. Гэтэл тэдгээр нь нийгмийн

¹³ Бертран Рассел. Өрнийн философийн түүх. Эртний философи. I боть, УБ., 2012, 10 дахь тал.

¹⁴ И. Кант. Трактаты и письма. М., 1980, С 332

амдралын бодит үзэгдэл үйл явцтай ямар нэг байдлаар холбогддог, бүгд л хүний оюун сэтгэхүйн үйл ажиллагааны үр бүтээл болж байдаг агуулгаараа нийтлэг боловч бас ялгаа онцлогтой. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд нийгмийн ухаанууд нь нийгмийн амьдралын бодит үзэгдлүүтэй шууд холбогдон, тэдгээрийн бодит баримт туршлагад илүүтэй суурилах маягтайгаар оюун сэтгэхүйн харьцангуй “практик оюун ухаан” буюу судалгааны эмпирик бодит арга хандлагыг түлхүү ашигладаг талтай* бол хүмүүнлэгийн мэдлэг нь нийгмийн амьдралын бодит үзэгдлүүд тэдгээрийн эмпирик баримттай шууд тулж биш, харин нийгмийн оюун санаа, ухамсарын хүрээний асуудлуудтай их төлөв холбогдож, судлал шинжлэлийн харьцангуй хийсвэр, сэтгэн бясалгах оюунлаг арга хандлагыг илүүтэй онцлох маягаар дам харьцаж байдаг. Тэгэхдээ хүмүүнлэгийн ухаанууд нь судалгааны бодит арга хандлагуудаас нэг их зай бариад байдаггүй ч (тодорхой хэмжээгээр ийм аргуудыг ашигладаг гэсэг үг) ихэнхдээ тэдгээр нь цэвэр хийсвэр, оюунлаг мэдлэг бүтээх чиглэлд илүүтэй анхаарлаа хандуулдаг байна.

ABSTRACT

Is philosophy a science? Or is it just a knowledge in humanities? This issue brings many controversies among philosophers. Some of them claim that it is a complete science, and others say it is just an education in humanitarian. So, the author shares his view on this very matter. Is philosophy a science or is it just a knowledge in humanities?

НОМ ЗҮЙ

1. Кант И. Трактаты и письма. М., 1980
2. Канке В.А Философийн үндсүүд. УБ., 2011
3. Рассел Бертран. Өрнийн мэргэн ухаан. УБ., 2011
4. Рассел Бертран. Өрнийн философийн түүх. Эртний философи. 1 боть, УБ., 2012
5. Болд-Эрдэнэ Д. Улс төрийн философи: удиртгал. (Тэргүүн боть) УБ., 2015
6. Хрестоматия по философии: учебное пособие. “Проспект”. М., 1998
7. Чулуунбаатар Г. Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик, судалгааны ажлын арга зүй. УБ., 2001